



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 16 өдөр

Дугаар 5/25

Ховд

М.Пүрэвхүүг ажилд шилжүүлэн томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 168 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлаг Соёлын хэлтсийн даргаар Мухраагийн Пүрэвхүүг 2021 оны 8 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн шилжүүлэн томилсугай.

2. М.Пүрэвхүүд Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээний ТЗ-10-ын 5 дахь шатлал 1088657 төгрөг /нэг сая наян найман мянга зургаан зуун тавин долоон/-өөр цалинжуулж, төрийн алба хаасны нэмэгдлийг 20 хувиар, зэрэг дэвийн нэмэгдлийг 26 хувиар тус тус үндсэн цалингаас тооцож олгохыг тус хэлтсийн нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.

3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг М.Пүрэвхүүд үүрэг болгосугай.

4. Тус захирамж гарсантай холбогдуулан Ховд аймгийн Засаг даргын 2021 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн Б/19 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.


ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02.2201
Zax B/25 Kh

Аймгийн Засаг даргын 2021 оны
08 дугаар сарын 16-ны өдрийн
Б/25 дугаар захирамжийн хавсралт



**АЖИЛ ХҮЛЭЭЛЦҮҮЛЭХ АЖЛЫН
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн
ахлагч:

Б.Даваадорж - Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Б.Нарандорж - Боловсрол, соёл урлагийн газрын
дэд дарга

Б.Батнасан - Боловсрол, соёл урлагийн газрын
мэргэжилтэн

Ч.Эрдэнэбат - Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн

Нарийн бичгийн
дарга:

Ж.Батбаяр - Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн
мэргэжилтэн